



Зураг: © Паносын зураг/Аббэй, Трейлер-Смит

2015 ОНД НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГААС ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛСЭН УЛС ОРНУУД

Хүмүүнлэгийн аливаа нөхцөл байдалд НҮБ-ын Хүн амын сан эх, нярайн амь нас, эрүүл мэндийг хамгаалахын төлөө ямар ч нөхцөл байдлаас үл хамааран эсэн мэнд амаржуулах эх барихын тусламжийг эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах үүрэгтэй.

	Тухайн үе дэх жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо /тооцоолсноор/
Буркина Фасо	598,610
Бурунди	373,871
Камерун	695,698
Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	150,727
Чад	472,898
Чили	193,042
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	2,753,898
БН Ардчилсан Солонгос Ард Улс	276,175
Джибути	21,836
Египет	1,991,512
Эритрея	134,236
Этиоп	2,711,606
Гватемала	365,965
Ирак	934,973
Йордан	157,846
Ливан	74,572
Малави	555,483
Мали	573,961
Мавритан	103,372
Мьянмар	609,344
Непал	517,850
Нигер	763,201
Нигерия	5,366,797
Палестин	128,179
Перу	473,691
Руанда	310,901
Сенегал	432,879
Сомали	373,756
Өмнөд Судан	244,317
Судан	860,404
Арабын БН Сири Улс	355,706
Танзани	1,605,941
Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон улс	17,611
Турк	945,434
Уганда	1,304,798
Украин	306,902
Вануату	6,839
Йемен	687,058
Нийт	28,451,889

* Сөргөлдөөн, эсвэл хямралд өртсөн бус нутаг төдийгүй, тухайн улс орон, газар нутаг дахь жирэмсэн байх магадлалтай эмэгтэйчүүдийн тоог үндэсний түвшний тоон мэдээ, мэдээллийг ашиглан тооцоолж гаргав. Иймд аливаа улс орон, газар нутгийн зөвхөн хямралд өртсөн хэсэг дэх хүн амын тоог ашиглаж тооцоол тухайн цаг үе дэх жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо арвай шүүн байх болно.

** Тоон мэдээ, мэдээллийн олоогоос хамааран Вануату улсын мэдээллийг төрөлтийн тусгай коэффициент бус харин төрөлтийн нийлбэр коэффициентийг ашиглан тооцоолж гаргав.

Мэдээллийн эх сурвалжууд:
Хүн ам зүй ба эрүүл мэндийн судалгаа: Буркина Фасо, Бурунди, Камерун, Чад, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Египет, Эритрея, Этиоп, Йордан, Малави, Мали, Мавритан, Непал, Нигер, Нигерия, Перу, Руанда, Сенегал, Танзани, Уганда, Йемен.
Хүн амын тооллого: Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Өмнөд Судан, Вануату.
Улсын бүртгэл: Чили, Гватемала, Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон улс, Турк, Украин.
Арабын орнуудын гэр бүлийн эрүүл мэндийн төсөл: Джибути, Ливан, Палестин.
Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэл судалгаа: Ирак, Сомали.
Урьдчилсан статистик: Мьянмар, Арабын Бүгд Найрамдах Сири Улс.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
605 3-р өргөн чөлөө
Нью Йорк, NY 10158
www.unfpa.org

Нүүрний зураг: © НҮБХАС/Нейк Батев
Дотор зураг: © Паносын зураг/Бриан Сокол



Дэлхийн хүн амын байдал 2015 Тайлангийн товч танилцуулга



ШУУРГАНААС ХОРОГДОХ БАЙР

Хямралд өртөмтгий улс орнууд дахь охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн шинэ зорилт

Дэлхийн II дайнаас хойш хамгийн олон буюу 100 сая гаруй хүнд одоо хүмүүнлэгийн тусламж үзүүлэх шаардлагатай байна.

Сөргөлдөөнөөс дайжсан эсвэл гамшгийн улмаас албадан шилжин суурьшихад хүрсэн иргэдийн 26 сая нь өсвөр насны охид, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд байгаа бөгөөд тэдний хэрэгцээ, эрхийг зайлшгүй хангах ёстой.

Хүмүүнлэгийн нөхцөл байдалд өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эрхийг хамгаалахад өнгөрсөн арван жилд мэдэгдэхүйц ахиц гарсан ч, энэхүү хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж, санхүүжилт, үйлчилгээний өсөлтийг ардаа орхиод байна. Гэтэл эдгээр үйлчилгээ нь ялангуяа өсвөр насны охидод онц шаардлагатай бөгөөд тэд бол тогтвортой тайван цаг үед ч нүүр тулсан олон бэрхшээлээ даван туулах чадвар сул, хамгийн эмзэг хүмүүс юм.

Тэгш бус байдлыг зориуд шийдэхэд чиглэсэн хүмүүнлэгийн төрөл бүрийн хөтөлбөрүүдийн хүрээнд охид, эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болсон цагт эдгээр үйл ажиллагааны үр дүн эрс нэмэгдэж, хямралын хүнд үеэс тухайн улс орон, олон нийт сэргээн босголтод шилжиж, хүн ардын амьжиргааг дээшлүүлж, ирээдүйг цогцлоох бүх үе шатанд энэ байдал хадгалагддаг.



Зураг: © НҮБХАС/Савиче Вамунза



Зураг: © Паносын зураг/Крис де Бде



Зураг: © НҮБХАС/Бен Мансер



Зураг: © Паносын зураг/Свен Торфинн



Дэлхийн II дайнаас хойш хамгийн олон буюу 59.6 сая хүн өнөөдөр хямралын улмаас албадан шилжин суурьшиж байна.



Дэлхийд эхийн эндэгдэлээрээ эхний 10-т ордог улс орнууд нь дайн самуунтай эсвэл дайнаас ангижирч буй орнууд юм.



Өнгөрсөн жил хүмүүнлэгийн тусламж үзүүлж буй улс орнуудад НҮБ-ын Хүн амын сан 20.8 сая эмэгтэй, эрэгтэй хүн, өсвөр үеийнхэнийг жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслээр хангав.



2014 онд НҮБ-ын Хүн амын сан 38 оронд хүмүүнлэгийн онцгой байдалд хариу арга хэмжээ авч, 35 сая хүнийг эм, бусад хэрэгсэл бүхий нөхөн үржихүйн эрүүл мэндийн багцаар хангав.



Өнгөрсөн жил Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хямралд хариу арга хэмжээ авахад түүхэнд хамгийн их буюу 19.5 тэрбум доллар шаардлагатай байсан ч, 7.5 тэрбум доллар дутсан нь түүхэнд байгаагүй үзүүлэлт юм.



Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд зарцуулж буй нэг доллар тутмын 60 орчим центийг онцгой байдлын үеийн аврах ажиллагаа, 35 центийг сэргээн босголт, 5 центийг бэлэн байдлыг хангахад зарцуулдаг.



Даван туулах чадварыг сайжруулахын тулд хүний эрх, түүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг хамгаалсан тэгш, бүхнийг хамарсан хөгжлийг хангах шаардлагатай.




НҮБ-ын Хүн амын сан гамшигт хариу арга хэмжээ авдаг байснаа цаашид гамшгийн бэлэн байдлыг хангаж, түүнийг даван туулахад тулхуу анхаарах замаар хүмүүнлэгийн шинэ зорилтуудыг хэрэгжүүлэхийг уриалж байна.

Охид, эмэгтэйчүүд харьцуулшгүй хүнд нөхцөлд байна

Хямрал, дайн, байгалийн гамшиг улам бүр газар авч, сунжирсан их үймээн самуун, сүйрэлийг араасаа дагуулах үед өсвөр насны охид, эмэгтэйчүүд ачааны хүндийг үүрч байна. Гэр бүл, олон нийтийн хамгааллын гадна орхигдсон өсвөр насны охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчинд байнга өртөж байна.

Эрүүл мэндийн тогтолцоо доголдоход өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, эсэн мэнд амаржих суурь хэрэгцээ бараг хангагдахгүй доголддог.



Тэд

- Бэлгийн замаар дамжих халдвар, түүний дотор ХДХВ-ийн халдвар
- Хүсээгүй жирэмслэлт
- Эхийн эндэгдэл, өвчлөл
- Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх эрсдэл ихсэж байна.

Хямралын эхнээс хэрэгжүүлэх гол арга хэмжээ, үйлчилгээнүүд

Ердөө 20-иодхон жилийн өмнөх үеийг хүртэл хүмүүнлэгийн хариу арга хэмжээний үед бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг ус, хүнс, хорогдох байрны дараа авч үздэг байлаа. Харин 1990-ээд оны эхнээс хийсэн маш олон судалгаа, баримтуудын үр дүнд охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг чухалчлах болсон юм. Өнөөдөр хүмүүнлэгийн олон арга хэмжээ жирэмслэлт, төрөлттэй холбоотой хэрэгцээг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн замаар дамжих халдвар, түүний дотор ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг шийдвэрлэхэд чиглэж байна.

Зорилго:

- 👤 Эх, нярайн эндэгдэлээс урьдчилан сэргийлэх
- 🦋 ХДХВ-ийн халдварыг бууруулах
- 👋 Бэлгийн хүчирхийллийн үр дагавараас урьдчилан сэргийлж, шийдвэрлэх

Эн тэргүүний үйлчилгээнүүд:

- Эх барих болон нярайн яаралтай тусламж
- Эх барихын хүндрэлтэй тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх тогтолцоо
- Халдвараас ангид, эсэн мэнд амаржуулахад шаардлагатай эм, хэрэгслийн хангамж
- Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслүүд
- Бэлгэвч
- Ретровирусын эсрэг эм
- Хүчингийн гэмт хэргийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж

Урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрх мэдэлжүүлэх

Гамшиг, сөргөлдөөн нь хүмүүс, олон нийт, байгууллага, улс үндэстэнд хүмүүнлэгийн томоохон цохилт болдог учраас үүнийг даван туулах чадварыг сайжруулах нь нэн чухал бөгөөд ингэснээр бүгд хямралын үр дагаварыг илүү хүчтэй сөрж, түүнийг хурдан даван туулах боломжтой болно.

Даван туулах чадварыг сайжруулсанаар өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд учирч болох сөрөг үр дагаваруудыг бууруулах боломжтой.

- ⚠ Эрсдэлийн менежментийг сайжруулах
- ⊕ Боловсрол, эрүүл мэндээр дамжуулан хувь хүмүүсийн даван туулах чадварыг сайжруулах
- 👋 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах боломжийг бүрдүүлэх
- ♀♂ Жендэрийн тэгш бус байдлыг бууруулах
- 🏛 Гамшиг болохоос өмнө институцийн чадавхийг бэхжүүлэх
- 🏠 Урт хугацаанд, бүхнийг хамарсан, тэгш хөгжлийг хангах

Хүмүүнлэгийн үйл ажиллагааны шинэ эрхэм зорилго

Хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь урт хугацааны хөгжлийн суурийг тавьдаг. Хөгжлийн үр шимийг бүгд хүртэж, хүн бүр өөрсдийн эрх түүний дотор нөхөн үржихүйн эрхээ эдлэх боломж бүхий хөгжлийг хангах нь хямралыг сөрөхөд хувь хүн, байгууллага, олон нийтэд тус дөхөм болдог.

Хариу арга хэмжээ авахаас эхлээд гамшгийг даван туулж, хөгжих хүртэлх хүмүүнлэгийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг анхаарлын төвд авч үзнэ.

